



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/40

Баянбулаг

“Эрүүл бэлчээр-Эрсдэлгүй малчны хот”
уриатай сэг зэм устгал, халдваргүйтгэлийн
ажил зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1, Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/206 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт байгалийн гамшгийн улмаас үхэж хорогдсон мал, амьтны сэг зэмийг 2023 оны 04 дүгээр сарын 20 –ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд малчид, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтарч стандартын дагуу устгах ажлыг зохион байгуулсугай.

2.Сэг зэм устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Батхонгор (Мал эмнэлгийн улсын байцаагч)

Гишүүдэд: Д.Энхтөр (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Т.Нямжанцан (Байгаль хамгаалагч)

Ш.Батболд (Гичгэнэ 1 дүгээр багийн Засаг дарга)

Ж.Уламбадрах (Дэлгэрэх 2 дугаар багийн Засаг дарга)

Б.Цэрэнпунцаг (Цэцэн 3 дугаар багийн Засаг дарга)

Д.Ариунаа (Жаргалант 4 дүгээр багийн Засаг дарга)

Г.Өлзий-орших (Баянбулаг 5 дугаар багийн Засаг дарга)

М.Цэвээнсүрэн (Хог хөтөлбөрийн жолооч)

Б.Даваадарь (Хог хөтөлбөрийн ажилтан)

3.Сэг зэм устгалын ажлыг чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

5.Мал, амьтны сэг зэм устгалын ажилд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогчид даалгасугай.

ДАРГА  Н.ГАНСҮХ



642301073